



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын  
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл  
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Биг авто молл ХХК-ийн “Нисдэг машин” зочид буудлын 20/445, Наргүнж ХХК -ийн “Наргүнж” зочид буудлын 20/459, Өү ди ти би ХХК-ийн “Дисковери” зочид буудлын 20/432, Царам трейд ХХК-ийн “Царам” дэн буудлын 20/312, Жингийн халзан ХХК-ийн “Харз 2” дэн буудлын 20/227, Билэгт учрал ХХК-ийн “Толгойт” дэн буудлын 20/444, Ар улаан чулуу ХХК-ийн “Соко” дэн буудлын 20/443, Бат-Олоц ХХК-ийн “Хүлэг” дэн буудлын 20/400, Хүч эбле таун ХХК-ийн “Тэрэлж Алтай ресорт” амралтын газрын 20/421 тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

1150590324

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

Нийслэлийн Аялал, жуулчлалын  
газрын даргын 2021 оны 11 сарын  
17-ны өдрийн А/76 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

1  
ТТ # 8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ


2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Биг авто молл ХХК	5546826	Нисдэг машин	ЧД-ийн 5-р хороо, Тасганы овоо 15/150, Их тойруу 23/1
2	Этүгэний хөх ус ХХК	5045506	Лион	БГД-ийн 1-р хороо, Хатанбаатар Магсаржавын гудамж
3	Эхийн лха ХХК	5125146	Топаз	СБД-ийн, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 29-р байр
4	Нар гүнж ХХК	5341973	Би Эйч	БГД-ийн 18-р хороо, 4-р хороолол /16063/ Л.Энэбишийн өргөн чөлөө 77
5	Өү Ди Ти Би ХХК	6102018	Дисковери	БГД-ийн 5-р хороо, 10-р хороолол, Энхтайваны өргөн чөлөө 49ж

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2021 оны 11 сарын  
17-ны өдрийн А/76 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ


2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Царам трейд ХХК	2777096	Царам	СБД-ийн, 12-р хороо, Хангайн 22-831
2	Жингийн халзан ХХК	2826461	Харз 2	СХД-ийн, 10-р хороо, Зүүн баян уулын 7-3 тоот
3	Билэгт учрал ХХК	5264103	Толгойт	СХД-ийн 2-р хороо, Орбит 21-368
4	Ар улаан чулуу ХХК	2699435	Соко	СХД-ийн 18-р хороо, Өнөр хороолол 13а
5	Бат-Олоц ХХК	5427517	Хүлэг	БЗД-ийн, 19-р хороо, Цайз

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2021 оны 11 сарын  
17-ны өдрийн А76 дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хүч эблэ таун ХХК	5705908	Тэрэлж Алтай ресорт	НД-ийн, 1-р хороо, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газар
2	Эрмүүн санаа ХХК	5101115	Төр хуралдай ресорт	БЗД-ийн 11-р хороо, Төр хурахын ам

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР